

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2021 ОНЫ
4 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 7 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг ханган ажилласан. Засаг даргын зөвлөлийн хурал 2 удаа зохион байгуулж, 5 асуудал хэлэлцэж шийдвэрлэсэн.

Аймгийн Засаг дарга 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр үйлдвэрлэл, хоршоо эрхлэгчидтэй цахим уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтаар “Төр-Хувийн хэвшлийн хамтын ажиллагааны салбар зөвлөл” байгуулсныг танилцуулж, цаашид үйлдвэрлэл, хоршоо эрхлэгчид үйл ажиллагаагаа өргөжүүлэн хамтран ажиллах, олон улсын болон дотоодын стандарт шаардлагыг хангасан бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлэх, орон нутгийн бренд бүтээгдэхүүн үүсгэх зэрэг санал, санаачлагууд гаргаж, хамтран ажиллахаар болсон. Цахим уулзалтад 55 үйлдвэрлэл, хоршоо эрхлэгч оролцож, санал бодлоо солилцсон.

2021 оны 3 дугаар сарын 14-ний өдөр хүчтэй шороон шуурга шуурсны улмаас аймгийн хэмжээнд 760 гаруй сая төгрөгийн хохирол учирсан. Гамшгийн хохирлыг бууруулах чиглэлээр орон нутгаас шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд эхний ээлжинд малчин өрхүүдэд аймгийн өвс тэжээлийн нөөцөөс 64 тонн өвс, 8.1 тонн тэжээлийг олгосон.

Мөн аймгийн Засаг дарга шороон шуурганы улмаас аймаг орон нутагт үүссэн хохирол, нөхцөл байдалтай холбогдуулан Улсын онцгой комисс, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам болон Улсын их хурлын гишүүн С.Батболд, Г.Мөнхцэцэг нарт албан хүсэлт хүргүүлснээр 150 тонн өвс, 120 тонн тэжээл, 300 өрхөд хүнсний тусламж, 5 иргэнд гэр олгосон.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2021 оны 4 дүгээр сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 2 382 937 мянган төгрөг төвлөрүүлэхээс 2 490 000 мянган төгрөг төвлөрүүлж, 105 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс улсын төсвийн орлогын төлөвлөгөө 348 482 мянган төгрөг төвлөрүүлэхээс 349 500 мянган төгрөгийг төвлөрүүлж 100 хувь, сумын төсвийн орлогын төлөвлөгөө 276 820 мянган төгрөг төвлөрүүлэхээс 276 900 мянган төгрөг төвлөрүүлж 100.2 хувь, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1 757 636 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1 925 000 мянган төгрөг төвлөрүүлж, 110 хувийн гүйцэтгэлтэй байна.

2021 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар татвар төлөгч хуулийн этгээд нийт 639 байна.

Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр: Ерөнхий боловсролын 1, 2 дугаар сургууль, Боржигин өв музей, Цөм сүргийн үржлийн төвийн 2019, 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, нийт 29 897 800 төгрөгийн зөрчил илрүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр

№	Төрөл	2020.04.25		2021.04.25	
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян.төг/
1	Өндөр настан	1592	2590850	1755	3672820
2	Хөгжлийн бэрхшээлтэй	310	141500	345	151850
3	Тэжээгчээ алдсан	121	371500	114	380952
4	Үйлдвэрлэлийн осол	52	201500	45	241000
Нийт дүн		2075	3305350	2259	4446622

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2020.04.25		2021.04.25	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян.төг/
1	ХЧТА тэтгэмж	942	89652	1208	65950
2	ЖБА тэтгэмж	246	151200	340	204500
3	Оршуулгын тэтгэмж	25	25000	28	28000
4	ҮОМШӨ-ХЧТА				
5	Ажилгүйдлийн тэтгэмж	89	103500	92	131500
	Нийт дүн	1302	369 352	1668	429 950

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2020.03.25	2021.03.25
Шинээр	35	52
Мөнгө тушаасан	202	205
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	48350	65320

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 416 заалт, 12708 хүний нэр, 554 байгууллагын нэр, 1945 газар зүйн нэр, 895 хуудас баримт программд холбосон. Архивын баримтаас 12 иргэнд лавлагаа мэдээлэл олгосон.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан - 15
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 39
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо - 34
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 1
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо - 1
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 8

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 8
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 11
- Гэрээний бүртгэл - 48
- Барьцааны гэрээний бүртгэл - 260
- Эд хөрөнгөнд орсон өөрчлөлт, залруулга - 7

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 4
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт - 9

Архивын чиглэлээр:

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 132
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 69

Нийт 647 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлсэн.

Цагдаагийн хэлтэс нь: 2021 оны 4 дүгээр сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 84 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгасан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 91 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” А/123 дугаартай захирамжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр байнгын 6 пост, хяналтын 10 цэгт сумдын Засаг даргын Тамгын газар, Онцгой байдлын газар бусад мэргэжлийн анги, байгууллагуудтай хамтран үүрэг гүйцэтгэж хорио, цээр болон хэсэгчилсэн хязгаарлалтын дэглэм тогтоож, үйл ажиллагаа явуулж байгаа хүн, хуулийн этгээдийн тогтоосон цагийн хязгаар, халдвар хамгааллын дэглэм сахиж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Камерын хяналтыг тогтмол ажиллуулснаар гэрэл дохио, зогсох, зогсоолын журам зөрчсөн 6 зөрчил илрүүлж, зөрчлийн тухай хуульд зааснаар хариуцлага тооцсон байна.

Хүүхдийг осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, бага насны хүүхдийг харгалзах хүнгүй үлдээх, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг, хариуцлага, хүүхдэдээ тавих анхаарал халамжийг нэмэгдүүлэх, сургууль, цэцэрлэг орчмын болон бусад олон нийтийн газруудад байрлалтай тоглоом, тоглоомын талбай нь MNS-6751:2019 стандарт шаардлага хангаж буй эсэхэд хяналт шалгалт хийж, орчны эрсдэлийг бууруулах зорилгоор 4 дүгээр сарын 6-9-ний өдрүүдэд “Тоглоомын талбай” хэсэгчилсэн арга хэмжээг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан.

Шүүхийн шинжилгээний алба нь: Хэргийн газрын үзлэгт 23 удаа оролцсоноос хүний амь эрсэдсэн хэргийн газрын үзлэгт 2, зам тээврийн ослын 3, хулгайлах гэмт хэрэг 3, бусад хэргийн газрын үзлэгт 15 удаа оролцож, хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 278 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар 425 дугаар нээлттэй хорих анги нь: Оёдлын сургалтад 7 хүмүүжигч, мужааны сургалтад 2 хүмүүжигчийг хамруулж ажлын байраар хангасан.

Хоригдлын авьяас, ур чадварыг хөгжүүлэх, дугуйлангуудад нийт 180 орчим хүмүүжигч хамрагдаж байна.

Онцгой байдлын газар нь: 4 дүгээр сарын 6, 7-ны өдрүүдэд Найрамдал хотхоны байрны орцнуудад цахилгааны ерөнхий самбар, ил цахилгааны утасны аюулгүй байдал зэрэгт үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар Бадрах-70 СӨХ-д Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн албан мэдэгдэл хүргүүлсэн.

Гал унтраах тархалтын сургуулийг “Политехникийн коллежийн дотуур байр”, “Политехникийн коллеж”, “1-р сургууль” зэрэг газруудад гарсан гал түймрийг унтраах талаар сургалтыг танхимаар зохион байгуулсан. тус сургалтад давхардсан тоогоор 18 алба хаагч хамрагдсан.

Шивээговь сумын 2 дугаар багийн “Найман шороот” гэдэг газар /аймгийн төвөөс баруун урд зүгт 35 км, сумын төвөөс урд зүгт 8 км-т, уртрагийн 108°46'27.5", өргөргийн 46°51'47,2"/ галт сум илэрсэн тухай дуудлагыг хүлээн авч, газар дээр нь очиж ажиллахад байлдааны болон сургуулийн нийт 17 ширхэг сум олсон. Эдгээр сумыг олдсон газраас Ниссан Пикап загварын автомашины тэвшин дээр элсэнд булаж зөөвөрлөн Сүмбэр сумаас урд зүгт 5 км-т аюулгүй байдлыг ханган буулгаж 2021 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр Зэвсэгт хүчний 084 дүгээр ангиас 5 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ирж, тухайн олдсон сумнуудыг устгасан.

Сүмбэр сум 3 дугаар баг Найрамдал хотхоны “Андууд” 8 нэрийн хүнсний дэлгүүрт утаа гарч байна гэсэн тухай дуудлагыг 2021.04.04-ний өдрийн 09:24 цагт өгсний дагуу Салааны бие бүрэлдэхүүн 2 автомашин 6 хүний бүрэлдэхүүнтэй 09:25 цагт гарч 1,8 км замыг туулан 09:27 цагт хүрэлцэн очиход гал гараад унтарсан байдалтай, утаа ихтэй байсан. Уг гал түймэрт өртөж бэртэж гэмтсэн хүн байхгүй.

Мэргэжлийн хяналтын газар нь: Тайлант сард 15 хяналтын чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтыг хийж, улсын байцаагчийн албан шаардлага 10, акт 2, дүгнэлт 3, зөвлөмж 5-ыг тус тус боловсруулж, хяналт шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад хүргүүлсэн.

Мөн 6 аж ахуй нэгж байгууллагад зөвлөн туслах хяналтын холбогдох заалтын дагуу арга хэмжээ авч нийт 2250 нэгжээр торгуулийн арга хэмжээ авч, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн.

Хими, нян судлалын лабораторид Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн 35 дээжид 128 үзүүлэлтээр шинжилгээг хийж хариуг баталгаажуулсан.

Аймгийн Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн “Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” А/109 дүгээр захирамжийн хүрээнд үйл ажиллагааг нь хязгаарласан 22 үйлчилгээний газрыг хамруулан төлөвлөгөөт бус хяналт, шалгалт хийж, 4 газрын үйл ажиллагааг газар дээр нь зогсоож, Зөрчлийн тухай хуулийн дагуу нийт 200 нэгжээр торгох арга хэмжээ авч, хялбаршуулсан журмаар шийдвэрлэн, үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа хүнсний худалдааны 5, хүнс үйлдвэрлэлийн 1, нийт 6 газрын халдвар хамгааллын дэглэмд хяналт хийж, 11 зөрчил илэрснийг газар дээр нь 100 хувь арилгуулсан.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй коронавирусын халдварын үед сорьц авах, түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийх байнгын 4, явуулын 4 нийт 8 цэгийн үйл ажиллагаанд эрүүл ахуй халдвар хамгаалал, эмчилгээний чанар, эм био бэлдмэлийн хяналтын чиглэлүүдээр дэмжлэгт хяналт хийлээ. Дэмжлэгт хяналтаар хүний нөөц, нэг удаагийн хамгаалах хувцас, эм эмнэлгийн хэрэгсэл, эрүүл ахуй халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлттэй холбоотой 14 зөрчил илрүүлж 4 зөрчлийг газар дээр нь арилгуулж 4 байгууллагад 10 заалт бүхий хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Боловсролын үнэлгээний төвөөс гаргасан “Ерөнхий боловсролын сургуулийн хичээл сургалтын үр дүнг үнэлэх, үнэлгээний шалгуур”-ыг турших ажлыг удирдамжийн дагуу зохион байгуулж байна.

Тогтвортой хөгжлийн боловсрол хөтөлбөрийн хүрээнд “Дэлхийн том хичээл-ТХБ” нэгж ээлжит хичээлийг боловсруулах, онлайн сургалтад сургуулийн өмнөх боловсролын арга зүйч, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежер, Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтнүүд хамрагдлаа. Сургуулийн өмнөх боловсролын хүрээнд 6 хичээл, Ерөнхий боловсролын сургуулийн хүрээнд 33 хичээлд үнэлгээ хийж, “Дэлхийн том хичээл”-ийн цахим сайтад шалгарсан 10 хичээлийг байршууллаа.

Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн 5-р шат”-ны сургалтад төсөл хариуцсан мэргэжилтэн хамрагдаж, орон нутгийн хэмжээнд сургуулийн захирал, бага ангийн багш нарын хүрээнд онлайн сургалт зохион байгууллаа.

Боловсролын хүрээлэнгээс Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд жил бүр зохион байгуулдаг эрдэм шинжилгээний хуралд Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн Англи хэлний багш нар “Дэвтрийн тэмдэглэлээр теле хичээлийн үр дүнг нэмэгдүүлэх боломж” сэдвээр оролцож, тусгай байранд шалгарч, үндэсний хэмжээнд туршлагаа түгээн дэлгэрүүлсэн.

2021 оны “Боловсролыг дэмжих арга хэмжээ”, “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III” хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу “Монгол бичгийг сурталчлах цахим уралдаан”-ы удирдамжийг боловсруулан батлуулж, зохион байгуулалтын ажлыг эхлүүлээд байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Жендэрт суурилсан ялгаварлан гадуурхалтыг бий болгож, охид эмэгтэйчүүдийн бэлгийн эрх чөлөө, халдашгүй дархан байдлын эсрэг хүний эрхийн зөрчлийн хандлага, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Цагдаагийн хэлтэстэй хамтран зорилтот өрхүүдэд чиглэсэн “Гэр бүлийн баяр хөөр-Хамтын аялал” сургалт зохион байгуулсан.

Жил бүрийн 4 дүгээр сард дэлхийн олон орны иргэд сайн дураараа нийгмийн сайн сайхны төлөө нийтэд тустай ажил өрнүүлэх зорилгоор “Сайн үйлсийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэхүү аяны хүрээнд 3 дугаар сарын 11-4 дүгээр сарын 11-ний өдрүүдэд дараах арга хэмжээг зохион байгуулсан.

1. Сайн үйлсийн өдрийн талаар олон нийтэд сурталчлан таниулсан.
2. Орон нутагт Сайн үйлсийг сурталчилсан 3 видео шторк бэлтгэн цахимаар хүргэсэн
3. “Гэрээсээ сайн үйлсийг хийх” санаачилга өрнүүлсэн.
4. "GOODSTOCK Олон улсын сайн үйлсийн цахим хурал" болоод "Сайн үйлсийн өдөр Монголд"-үндэсний цахим хурлыг зохион байгуулсан

Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгохтой холбоотой мэдээлэл өгөх, ахлах ангийн сурагчдыг мэргэжлээ буруу сонгох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, мэргэжил сонголтод арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн нийт 24 сурагчид бүлгийн сургалт, 4 хүүхдэд ганцаарчилсан зөвлөгөө өгч, мэргэжлийн хэв шинжийг тодорхойлох тест ажиллуулж, зөвлөгөө өгсөн.

Соёл, урлагийн чиглэлээр: “Нийтийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн ажлын нээлтийн үйл ажиллагааг цахимаар явууллаа. Нээлтийг аймгийн Засаг дарга нээж үг хэлж, чуулгын уран бүтээлчид урлагийн тоглолт тоглож, биеийн тамир спортын газрын албан хаагчид ажлын байрны дасгал хийж гүйцэтгэн, иргэд олон түмэнд сурталчилж үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Нийтийн номын сан уншигч иргэд, хүүхэд багачуудад зориулан хүүхдийн үлгэрийн ном болон зохиолын номуудыг цахимаар байгууллагынхаа уншигчдад хүргэн, 14763 уншигч хамрагдсан байна.

Спортын чиглэлээр: Биеийн тамир, спортын газраас өглөө бүр “Сүмбэр гарден” соёл, амралтын хүрээлэнд гүйлт, дасгалыг волейбол, хөл бөмбөг, иог, аэробик, хийн дасгал, хөгжилтэй буухиа, гимнастик, спортын бүжиг зэргээр зохион байгуулж, давхардсан тоогоор 13 байгууллагын 288 албан хаагч, иргэд хамрагдлаа.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2020 оны 04 сарын 20-ны байдлаар	2021 оны 04 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	146	130
Гэрийн төрөлт	0	2
Амьд төрсөн хүүхэд	148	134
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	23	21
Эмнэлгийн нас баралт	1	5
Хоног болоогүй нас баралт	0	3
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	1 703	945
Амбулаторийн үзлэг	33 495	28 279
Халдварт өвчин	32	9

Аймгийн хэмжээнд 2021 оны 1 дүгээр сарын 1-4 дүгээр сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд давхардсан тоогоор 6889 хүнд ПГУ/PCR-ийн шинжилгээ, 5335 хүнийг түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд хамруулсан байна.

Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын үйл ажиллагааг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлыг Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/183 дугаар тушаалын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Эрүүл мэндийн яамнаас хуваарилсан Коронавирусийн эсрэг Синофарм үйлдвэрийн “Вероцелл” вакцины 1 дэх тунгаар Эрүүл мэнд, Онцгой, Цагдаа, Тагнуул, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг хамруулж, нийт 1943 хүнийг дархлаажуулалтад хамруулаад байна.

Өнөөдрийн байдлаар Коронавируст халдварын батлагдсан 37 тохиолдол бүртгэгдэж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт эмчлүүлж буй 13 иргэн байна. Халдварын шинж тэмдэг илэрсэн эмнэл зүйн хүндэвтэр, хүнд, нэн хүнд тохиолдолд хэрэглэх вирусийн эсрэг /Арбидол, Фавипиравир, Ремидесивир/ эм, тариаг татан авч бэлэн байдлыг хангасан.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/102 дугаар тушаалын дагуу хуваарилсан 84.6 сая төгрөгийн хамгаалах хувцас хэрэгслийг Коронавируст халдварын цар тахлын эрсдэлээс сэргийлэх, зорилгоор эрүүл мэндийн байгууллагуудад хүргэлээ.

Улсын төсвийн хөрөнгөөр баригдсан 100 ортой аймгийн Нэгдсэн эмнэлгийн барилга ашиглалтад орж, эмнэлгийн тусламж үйлчилгээ хэвийн явагдаж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний чиглэлээр: Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээнд 12 иргэнийг хамруулсан. Нийт 112 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох ганцаарчилсан зөвлөх үйлчилгээг үзүүлж, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр арга хэмжээ, ажил олгогчоос ирүүлсэн ажлын байрны зар мэдээллийг хүргэсэн.

Ажил олгогч аж, ахуй нэгж байгууллагаас 36 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг авч, 12 иргэнийг байнгын ажлын байранд, 23 иргэнийг түр ажлын байранд, 3 иргэнийг улирлын ажлын байранд зуучилж, ажилтай орлоготой болгосон.

2018-2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд хамрагдсан 58 иргэний 35193.3 мянган төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлсэн.

2021 оны 4 дүгээр сарын байдлаар нийгмийн халамжийн сангаас дараах хөнгөлөлт, үйлчилгээнүүдийг үзүүллээ. Үүнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэр 253 хүнд 177.5 сая төгрөг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 248 хүнд 90.9 сая төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 220 хүнд 66.8 сая төгрөг
- Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 486 хүнд 7.7 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж 49 хүнд 3.8 сая төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа 671 хүнд 23.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2021 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар Малх отрын бүсэд 5 аймгийн /Дундговь, Өвөрхангай, Баянхонгор, Төв, Говьсүмбэр/ 112 өрхийн 96.0 мянган төл мал, отрын бүсээс гадна 126 өрхийн 82.0 мянган төл мал оторлож байна.

Төллөвөл зохих 166173 эх малаас 75242 эх мал төллөж, мал төллөлт 45.3 хувьтай байна. 75499 төл гарснаас 70937 нь бойжиж, бойжилт 94 хувьтай байна. Төлийн хорогдол 4562, буюу 6 хувь, том малын хорогдол 14590 буюу оны эхний нийт малаас 3.2 хувь нь хорогдсон байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 300 малчин өрхөд хүнсний тусламж үзүүлэхээр тусламжийн бараа нь ирсэн ч аймгийн онцгой комиссын шийдвэрээр хөл хорио тогтоосонтой холбоотойгоор малчдад тараах ажил хүлээгдэж байна.

Монгол улсын Засгийн газраас “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-нд тусгагдсан “Ажлын байрыг дэмжих 2 их наяд төгрөгийн зээл” олгох ажлын хүрээнд орон нутгийн үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж, иргэдэд ажлын байраа хадгалах, бизнесийн үйл ажиллагаагаа тогтвортой явуулахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийг бүрдүүлэх зээлийн нөхцөл, батлан даалтын үйл ажиллагааны талаар видео контент бэлтгэн байгууллагын цахим хуудсаар болон орон нутгийн телевизээр иргэдэд хүргэсэн.

Энэхүү зээлд хамрагдахаар нийт 285 иргэн, аж, ахуй нэгж байгууллагаас хүсэлт ирүүлснээс 4 538 891 000 төгрөгийн зээлийг 49 иргэн, аж, ахуй нэгж байгууллагад шинээр олгож, 28 688 889 төгрөгийн зээлийг 3 иргэн, ААНБ-ын зээлийг хөрвүүлээд байна.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2021 оны 04 дүгээр сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй зарим хүнсний бараа бүтээгдэхүүний үнэ өнгөрсөн сараас 20-1000 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тухайлбал: үхрийн мах /ястай, цул/ 500 төгрөгөөр, Хонины мах /ястай, цул/ 500-1000 төгрөгөөр нэмэгдсэн байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонь, ямааны махны үнэ 1000 төг, хүнсний ногоо 500-1000 төг, цагаан будаа 300-500 төг, сүү 150 төг, ургамлын тос 400 төг-өөр тус тус нэмэгдсэн байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан /3-р сараас /	
1	Үхрийн мах	Ястай	11000	10000	+500
	Цул		13000	12000	-
2	Хонины мах	Ястай	9000	8500	+500
	Цул		12000	11000	+1000
3	Адууны мах	Ястай	6500	6000	-
	Цул		8500	8000	-
4	Ямааны мах	Ястай	7000	6500	-
	Цул		9500	9000	-
5	Лууван	Монгол	1800	1000	-
	Хятад				
6	Төмс	Монгол	1300	850	-
	Хятад				
7	Байцаа	Монгол	2000	1800	-
	Хятад				-
		Монгол	8500	7000	-

8	Чинжүү	Хятад	7500	4500	
9	Манжин	Монгол	2000	1500	
		Хятад			-
10	Сонгино бөөрөнхий	Монгол	4000	1800	-
		Хятад	-	1400	-
11	Улаан лооль	Монгол	7500	5500	-
12	Өргөст хэмх	Монгол	7500	6500	-
13	Элсэн чихэр	Монгол	3000	2300	-
14	Будаа	Цагаан задгай кг	3000	2400	-
		Шар слава кг	3500	3000	-
		Гурвалжин будаа кг	3800	2200	-
15	Сүү	Задгай	3450	3000	-
		Сүү ХХК 0,5л			
		Сүү ХХК 1л	3200	2900	-
16	Тараг	Задгай	2200	2000	-
		Сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
17	Талх	Чойр талх	1200	1150	-
18	Өндөг	Монгол	550	450	-
19	Алтан тарианы гурил	Задгай дээд	1520	1480	
		Задгай 1-р зэрэг	1210	1100	-
		Задгай 2-р зэрэг	1000	950	-
		Савласан д/дээд /	2400	2300	-
		Савласан дээд	2200	2100	-
		Савласан 1-р зэрэг	1400	1300	-
		Савласан 2-р зэрэг	1500	1450	-

20	Ургамлын тос	Олейна	5500	5200	-
		Алтан	4500	4500	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Байгаль орчин, аялал жуулчлалын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг дархан цаазат ховор амьтан болох аргаль хонинд зориулан нэмэлт өвс тэжээл /биотехник/ арга хэмжээний хүрээнд Улсын тусгай хамгаалалттай Чойрын богд ууланд зэрлэг амьтдын байршиж буй 7 байршил газарт 50 боодол өвс тараан байршуулсан.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын 2021 оны Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний төслийг хянан батлах ажлыг зохион байгуулж, 16 аж ахуйн нэгж, байгууллагын төлөвлөгөөг батлаад байна.

Аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 4 аж ахуйн нэгж, байгууллагын 2021 оны ус ашиглуулах дүгнэлтийг гаргаж хүргүүлсэн.

Зөвшөөрөлгүй ус ашиглаж үйл ажиллагаа явуулж байсан 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу 1 500 000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авахуулж зөрчлийг арилгуулсан.

Агаарын чанарын хяналтыг хийж, 4-р сарын 1-ээс 4-р сарын 19-ны дээжинд шинжилгээ хийхэд дундаж азотын давхар исэл (NO₂) 0.012 мкг/мг, сарын хүлцэх агууламж хэмжээ 0.050 мкг/мг хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.017 мкг/мг байгаа нь хүлцэх агууламжаас хэтрээгүй байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Инженерийн шугам сүлжээ бүхий газруудын хамгаалалтын зурвасыг бүртгэлжүүлэх, мэдээллийн санд оруулах, цаашлаад давхцал үүсгэхгүй байхад анхаарах зорилгоор улсын хэмжээнд “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д шугам сүлжээ бүхий газруудын хамгаалалтын зурвасыг оруулах, бүртгэх ажил хийгдэж аймгийн хэмжээнд 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 14 төрлөөр 465 нэгж талбарыг хамруулаад байна.

Аймгийн хэмжээнд газраа 2 жил дараалан ашиглаагүй болон бүрэн ашиглахгүй хагас дутуу барилга байгууламж барьсан нийт 72 нэгж талбарын судалгааг гарган, газар эзэмшигч, ашиглагч нарт албан мэдэгдэл хүргүүлэн ажилласан.

Худалдан авах ажиллагааны талаар: Төсвийн ерөнхийлөн захирагчаас 2021 онд нийт 1 725 405 5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 24 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 12 тендер шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 2 ажил, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 15 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 9 ажлын тендер шалгаруулалтыг, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 5 ажил хийгдэхээр төлөвлөснөөс 4 ажлын тендер шалгаруулалтыг, Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлын тендер шалгаруулалтыг зарлан, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад байна. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар оруулалтаар хийгдэх 1 ажил төлөвлөснөөс 1 ажлыг зарлан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn, govisumber.gov.mn сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтыг 100 хувь цахим хэлбэрээр явуулж байна. Тендер шалгаруулалтын үр дүнг тухай бүрт нь цахим системд оруулсан.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор 18,16,14 дүгээр зөрлөг, сумын төвийн нийтийн эзэмшлийн 19 цэгийн 7366 м2 талбайг халдваргүйжүүлсэн.

Сумын нөөцөд 330 боодол өвс, 0.75 тн тэжээлийн үлдэгдэлтэй байна. Аймгийн нөөцөөс 1965 боодол өвс ирүүлснээс 24 өрхөд 470 боодол өвс олгож, 1495 боодол өвс үлдсэн байна.

2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр “Хамтын хүчээр элснээс салъя” арга хэмжээг зохион байгуулж, халдвар хамгааллын дэглэмээ баримтлан багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, байгууллагууд оролцож, сумын нийт талбайн 50 хувийг цэвэрлэсэн.

Шивээговь сум: Илчлэг шивээ ОНӨҮГ-ын хуучирч муудсан зуухыг сольж шинээр 2.3 мвт-ын хүчин чадалтай 2 зуухыг улсын төсвийн 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийлүүлж, суурилуулж байна. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай байна.

22-р зөрлөгийн гарман дээр нэг хяналтын пост 24 цагаар 8 байгууллагын 30 албан хаагч хуваарийн дагуу ажиллаж сумруу орж гарах тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавин ажиллан, төмөр замын 5 нүхэн гарцыг хааж хулгайн тээврийн хэрэгсэл явах нөхцөлийг таслан зогсоож, нийтийн эзэмшлийн гудамж талбай, хүүхдийн тоглоомын талбай бүхий 23 цэгийн 72600 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэж, 2 банк, хүнсний худалдаа эрхэлдэг 10 дэлгүүрт агаарын ариутгал хийн, ойрын хавьтлын 15 хүн, түүний гэр бүлийн 25 гишүүн, Улаанбаатар хотоос ирсэн 12 иргэн, гэр бүлийн 2, нийт 54 иргэн гэрийн ажиглалт, тусгаарлалтад авч ажиллав. Сум дотор хөдөлгөөнт эргүүлд 4 машины 12 алба хаагч, явган эргүүлд сургууль, цэцэрлэгийн багш нар ээлжээр өдөрт 4 хүний бүрэлдэхүүнтэй эргүүл хяналтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Сумын штабт ЗДТГ-ын албан хаагчид хуваарийн дагуу жижүүрлэн мэдээ, тайланг цаг хугацаанд нь гаргаж, хүргүүлэн ажиллаж байна. Иргэдийн сум хооронд нэвтрэх зөвшөөрлийг сумын Засаг даргын орлогч олгож өнөөдрийн байдлаар 36 иргэн зөвшөөрөл авсны дийлэнх хувийг 13а маягтаар олгосон байна.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас олгосон Ариутгалын автоклав-1, пульсоксометр-1, отсос-2, хяналтын монитор-1, автомат дуслын шахуурга-1, судас тодосгогч-1, нийт 11 836 000 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, 10 төрлийн 13 941 813 төгрөгийн үнэ бүхий нэг удаагийн хамгаалах хэрэгслийн хүлээн авсан.

Сумын нийтийн их цэвэрлэгээг 3 удаа зохион байгуулж, 5 аж, ахуйн нэгж, байгууллагын 113 ажилтан албан хаагч, иргэд 6 га талбайн 12 тн хог хаягдал, шороон шуурганы улмаас үүссэн элсийг ачиж, төв хогийн цэгт төвлөрүүлсэн.

Орчны бохирдлоос шалтгаалсан халдварт өвчлөл тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сэг зэм устгалын ажлыг 4 дүгээр сарын 7,8,9-ний өдрүүдэд зохион байгуулж, нийт 1275 сэг зэмийг гурван цэгт халдваргүйжүүлэлт хийж, булаж устгасан.

Сүмбэр сум: “Эко өглөө” арга хэмжээг 7 хоног бүрийн Лхагва гариг бүр байгууллагын албан хаагчид нийтийн эзэмшлийн эзэмшлийн гудамж талбайн хогийг түүж, цэвэрлэн ажиллаж байна.

Сүмбэр сумын ЗДТГ, U@M нэгдэлтэй хамтран хүүхэд багачуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, тэднийг үлгэрээр дамжуулан амьдралын зөв дадал хэвшилтэй болгох зорилгоор үлгэрийн цаг арга хэмжээг цуврал болгон хүргэж эхлээд байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР